

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
12 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

| <b>№</b> | <b>Баримтын агуулга</b>  | <b>Хуудасны дугаар</b> |
|----------|--|------------------------|
| 1.       | Хуралдааны товч тэмдэглэл:   | 1-10                   |
| 2.       | Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:  | 11-134                 |
|          | 1.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 13-91                  |
|          | 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /эцэслэн батлах/   | 91-92                  |
|          | 3.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /эцэслэн батлах/   | 93-104                 |
|          | 4.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/   | 105-117                |
|          | 5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /хэлэлцэх эсэх/  | 117-120                |
|          | 6.Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай хуулийн төсөл /хэлэлцэх эсэх/  | 120-130                |
|          | 7.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хуулийн төсөл /хэлэлцэх эсэх/  | 130-134                |

## ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

**Гурав.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament хэлэлцүүлгийн программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 24

Бүгд: 69

65.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

### **Хамт өргөн мэдүүлсэн:**

1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 19

Бүгд: 69

72.5 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51  
Татгалзсан: 18  
Бүгд: 69

73.9 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 20  
Бүгд: 69

71.0 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45  
Татгалзсан: 24  
Бүгд: 69

65.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

*Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.*

## **ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Гурав.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /эцэслэн батлах/**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалтууд явуулна.

Байнгын хороо эцэслэн батлуулах төслийн хувилбарыг бэлтгэж гишүүдэд тараасан байгаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль баталсанд тооцно гэж заасан.

Монгол Улсын нутаг дэвсгэр монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Эрх, үүрэг, хариуцлага хоёрыг орон нутагт шилжүүлсэн. Тэр хэмжээгээр хяналтыг чангатгах бус хуулиудыг бусад хуулиудаар бэхжүүлж, органик хуулийг сайжруулна.

Санал хураалтад 69 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, нийт гишүүдийн олонх. хуралдаанд оролцсон гишүүдийн 65.2 дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

1.Хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 69 гишүүн оролцож 50 гишүүн дэмжиж хуралдаанд оролцсон гишүүдийн 72.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хууль батлагдлаа.

2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя.

Санал хураалт

51 гишүүн дэмжлээ. Нийт гишүүдийн олонх буюу чуулганы хуралдаанд оролцсон 69 гишүүний 51 нь буюу 73.9 хувь нь дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль  
writer.chimege.mn яриаг бичвэрт хөрвүүлэв.

хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя.

#### Санал хураалт

69 гишүүн оролцож 49 гишүүн дэмжиж, чуулганд оролцсон гишүүдийн 71 хувиар, нийт гишүүдийн үнэмлэхүй олонхоор хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

4.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түний удирдлагын тухай хуулийг хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя.

Техникийн саатал гарсан байна. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Санал хураалт 69 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж 65.2 хувиар хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдлаа.

Хуулийн төслүүд эцэслэн батлагдлаа. Хууль санаачлагч Дуламдоржийн Тогтохсүрэн нарын гишүүд, ажлын хэсэг Жамъянхорлоогийн Сүхбаатар нарын гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалд орно.